



МҮХАҮТ

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ



2023.04.05

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Дугаар / 23.03




Lady 2023

ENTREPRENEUR

БИЗНЕС ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

2023.03.28 | МҮХАҮТанхим



МҮХАҮТ, Бизнес академи, Азийн сан, Бизнесийн ёс зүйн төв, Рио Тинто хамтран “LADY ENTREPRENEUR” ёслолын үйл ажиллагааг “Бизнес дэх эмэгтэйчүүдийн манлайлал” сэдвийн хүрээнд шинэ өнгө төрх, шинэлэг хэлбэрээр зохион (2023.03.28) байгууллаа. Арга хэмжээнд 200 гаруй бизнес эрхлэгч эмэгтэй оролцож, ёс зүйтэй манлайллын талаар хэлэлцэв.

Үндэсний үйлдвэрлэгч Энтерпренёр хатагтай: **ГРИЙН ГРУПП ХХК**

Экспортлогч Энтерпренёр хатагтай: **ХАНБОГД КАШИМЕР ХХК**

Хөрөнгө оруулагч Энтерпренёр хатагтай: **АШИД БЭХИ ХХК, ТЕХНИК ИМПОРТ ХК**

Импортлогч Энтерпренёр хатагтай: **ЭРДЭНЭЗОО ТРАНС ХХК, НАНО ИНТЕРНЭЙШНЛ ХХК**

Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Энтерпренёр хатагтай:

ХАРАА СҮМБЭР ХХК, ОЙ ПАРТНЕРС ХХК

Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч Энтерпренёр хатагтай: **МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ**

Дэвшилтэт, техник, технологи Ноу-Хау нэвтрүүлэгч Энтерпренёр хатагтай: **БАРЛОВОРЛД МОНГОЛИА ХХК**

Байгальд ээлтэй үйлчилгээ эрхлэгч Энтерпренёр хатагтай: **ЖАМОТОРАБЭРҮ ХХК**

Гарааны бизнес эрхлэгч Энтерпренёр хатагтай: **ТУЛГА ТӨХӨӨРӨМЖ ХХК**

Үйлчилгээний Энтерпренёр хатагтай: **ДА ХҮРЭЭ ТРЕЙД ХХК**

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч Энтерпренёр хатагтай: **ЦАЙДАМ ТРЭЙД ХХК**

LADY ENTREPRENEUR 2023:

Гран при: **ТЭСО ГРУПП ХХК**



ДАРААГИЙН НҮҮРЭНД ...>



МҮХАҮТ-ын салбар Танхимууд тайлангаа хэлэлцлээ




Монгол-Австрийн бизнес форум зохион байгууллаа



Харвард Менеж-Ментор хөтөлбөрийн шинэ элсэлтийн бүртгэл үргэлжилж байна



“Санхүүжилт татах боломж – Тогтвортой санхүү болон ногоон бонд” сэдэвт хэлэлцүүлэг боллоо



Гадаадын хөрөнгө оруулал татах, аялал жуулчлалыг дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх талаар хэлэлцэв



Үндэсний чанарын шагналтнууд тодорлоо



Катар-Кувейт-Монголын бизнес форумуудыг зохион байгуулав



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

МҮХАҮТ–ын салбар Танхимууд тайлангаа хэлэлцлээ

МҮХАҮТ нь 21 аймагт салбар Танхимтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тус салбар Танхимуудын 2022 оны үйл ажиллагааны тайлангийн хурлыг 2023 оны 3 дугаар сарын 22–ны өдөр зохион байгуулав. Тайлангийн хуралд 21 аймгийн салбар танхимын дарга, менежер нийт 40 гаруй хүн хамрагдав. Салбар Танхимууд өнгөрсөн онд орон нутагт бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэднийг чадавхжуулах сургалт, уулзалт хэлэлцүүлэг болон үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр нийтлэг үйл

ажиллагаагаа явуулсан байна.

2022 онд үйл ажиллагаагаараа тэргүүлсэн шилдэг салбар Танхим болон менежерүүдийг шалгаруулахад, Орхон, Хэнтий, Өвөрхангай аймгийн ХАҮТ Орон нутгийн шилдэг танхимаар, Архангай аймаг дахь ХАҮТ–ын менежер П.Бямбасүрэн, Дархан–Уул аймаг дахь ХАҮТ–ын менежер А.Сарандэлгэр, Өвөрхангай аймаг дахь ХАҮТ–ын менежер Д.Мягмарсүрэн нар шилдэг менежерээр шалгарлаа.



Монгол–Австрийн бизнес форум зохион байгууллаа



МҮХАҮТ–аас Австрийн эдийн засгийн танхим (WKO), Монгол Улсаас Австри Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран Монгол–Австрийн бизнес форумыг (2023.03.20) амжилттай зохион байгууллаа. Бизнес форумд Монгол Улсаас нийт 6 аж ахуйн нэгжийн 11 төлөөлөгч оролцсон бол Австрийн талаас 30 гаруй аж ахуйн нэгж оролцож хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар мэдээлэл солилцож, эрдэс баялаг, цахим боловсрол, эрүүл мэнд, хүнсний хангамж болон аюулгүй байдлыг сайжруулах, аялал жуулчлалын

салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгаль орчинд ээлтэй, ухаалаг хотыг хөгжүүлэхэд хамтран ажиллах боломжийн талаар ажил хэрэгч хэлэлцүүлэг өрнүүлээ.



Харвард Менеж–Ментор хөтөлбөрийн шинэ элсэлтийн бүртгэл үргэлжилж байна

МҮХАҮТ–ын дэргэдэх Бизнес академид хэрэгжүүлж буй Harvard Business Publishing– ний Harvard ManageMentor

(Харвард – Менеж Ментор) Монгол дахь хөтөлбөрийн төгсөлт боллоо. Дэлхийн шилдэг боловсролыг эх орондоо, эх



хэлээрээ эзэмшиж, монгол менежерүүдэд манлайллын ур чадвар, карьераа өсгөх боломж олгож байгаа энэхүү хөтөлбөрийн энэ удаагийн курсийг 50 гаруй менежер, дунд, түүнээс

дээш шатны удирдлагууд төгсч Харвард Бизнес Пабблишингийн сертификатыг гардаж аваад байна. Дараагийн сургалт 4 дүгээр сард эхлэх бөгөөд элсэлт үргэлжилж байна.

“Санхүүжилт татах боломж – Тогтвортой санхүү болон ногоон бонд” сэдэвт хэлэлцүүлэг боллоо

МҮХАҮТ, Санхүүгийн зохицуулах хороо, Олон улсын санхүүгийн корпораци, Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо хамтран “Санхүүжилт татах боломж–Тогтвортой санхүү болон ногоон бонд” сэдэвт хэлэлцүүлэг уулзалтыг байгууллаа. Уулзалтаар ТОП–100 аж

ахуйн нэгжүүдэд тогтвортой санхүүжилт, ногоон бондын ач холбогдол, тэдгээрийн зохицуулалтын орчны талаар мэдээлэл өгч, аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах боломж, дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн талаар танилцуулж, санал солилцов.



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

Гадаадын хөрөнгө оруулал татах, аялал жуулчлалыг дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх талаар хэлэлцэв

МҮХАҮТ, Гадаадын иргэн харьяатын газар (ГИХГ)-тай хамтран тус газраас үзүүлж буй үйлчилгээ, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын эрх зүйн орчин, хөрөнгө оруулагч, жуулчны виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл, цахим визийн www.evisa.mn системийн танилцуулга хийж, хувийн хэвшлийн төлөөлөлтэй санал солилцох, бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудлыг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хамтарсан санал,

дүгнэлт гаргах уулзалтыг (2023.03.30) зохион байгууллаа. Уулзалт, зөвлөгөөнд Америкийн Нэгдсэн Улсын ЭСЯ, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын ЭСЯ, БНХАУ-аас Монгол Улсад хөрөнгө оруулагчдын Зунхуа нийгэмлэг, МҮХАҮТ-ын дэргэдэх Аялал жуулчлалын зөвлөл, уул уурхай, барилга тоног төхөөрөмж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын нийт 90 гаруй төлөөлөгч оролцов.



МҮХАҮТ нь стандарт, чанарын асуудлыг эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, аж ахуй нэгжүүдийг

дэмжих талаас нь илүү анхаарч ажилладаг. Энэ хүрээнд хууль эрх зүйн орчныг сайжруулах, аж ахуйн нэгжүүдэд олон улсын менежментийн тогтолцоог

Үндэсний чанарын шагналтнууд тодорлоо

нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээнд тавигддаг олон улсын чанарын стандартын шаардлагыг таниулах чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ, сургалтуудыг зохион байгуулж ирсэн. Эдгээрийн нэг нь СХЗГ-тай хамтран жил бүр зохион байгуулдаг Үндэсний чанарын өдрийн арга хэмжээ болон Үндэсний чанарын шагналын шалгаруулалт юм.

“Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн нэгдсэн хэлэлцүүлгийн нээлтийн үеэр Үндэсний чанарын шагналыг гардуулсан бөгөөд

2022 ОНЫ ҮНДЭСНИЙ ЧАНАРЫН ШАГНАЛЫН:

- “Шилдэг аж ахуй нэгж, байгууллага” номинацид – Кашмер холдинг ХХК
- “Шилдэг бүтээгдэхүүн” номинацид – Милко ХХК-ийн “Зөв брэнд”
- “Шилдэг үйлчилгээ” номинацид – Барловорлд Монголиа ХХК-ийн Машин тоног төхөөрөмжийн эд ангиудын шинэ болон ашигласан тос, тосолгооны материал, хөргөлтийн шингэний иж бүрэн шинжилгээ тус тус шалгарав.

Катар–Кувейт–Монголын бизнес форумуудыг зохион байгуулав

МҮХАҮТ Катар Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монгол Улсаас Кувейт Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран Катар–Монголын бизнес форумыг 2023 оны 03 дугаар сарын 6-ны өдөр, Кувейт Улсын худалдаа, аж үйлдвэрийн танхим, Кувейт Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яам хамтран “Кувейт – Монголын бизнес форум”-ыг 2023 оны 03 сарын 8-ны өдөр

Кувейт хотноо тус тус зохион байгууллаа. МҮХАҮТ-ын дарга Т.Дүүрэн Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдааны орчин нөхцөл, хөрөнгө оруулалтын төслүүдийн талаар танилцуулж, МҮХАҮТ нь хамтын ажиллагааны хүрээнд хоёр улсын бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд бүх талаар дэмжин ажиллахаа илэрхийллээ.



4-Р САРД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД:

4 дүгээр сарын 5

Монгол Тайванийн аялал жуулчлалын боломж уулзалт

4 дүгээр сарын 15

“Хоккайдо 2023” байгаль орчин, уур амьсгалын олон улсын үзэсгэлэн, туршлага судлах аялал

4 дүгээр сарын 19-21

Эм, эмийн бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэн /CPHI Japan 2023/

4 дүгээр сарын 20

Монгол Унгарын бизнес уулзалт (цахим)

7727-7070

